



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 5 дугаар сар

## Гадаад худалдааны эргэлт: \$3,316.3 сая

**Мөнгөн дүн** тайлант хугацааны эцэст 3,316.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18.3%-иар буюу 743.5 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 58.6 сая ам.доллараар, импорт 684.9 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв.

**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 63.1% буюу 2,093.2 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12.9% буюу 426.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 4.3%-иар өссөн бол ОХУ-тай хийсэн худалдаа 2.8%-иар буурчээ.

## Гадаад худалдааны нийт тэнцэл: \$422.3 сая

**Мөнгөн дүн** 2015 оны эхний 5 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 626.3 сая ам.доллараар буурснаар 422.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 3.0%-иар буурсан ч импорт түүнээс өндөр дүнгээр буюу 32.1%-иар буурсантай холбоотой байна.

**Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг** 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан. Гэвч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү нэмэгдсэн. 2015 он гарсаар зэсийн баяжмалын экспортын нөлөө тогтворжиж, барааны эргэлтийн өсөлт буурсан.

## Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$518.1 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2015 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 518.1 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 601.5 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй импорт 33.56%-иар буурсан нь нөлөөлсөн.

## Гадаад худалдааны нөхцөл: 1.738 (Туршилт тооцоо)


2015 оны 5 дугаар сарын байдлаар гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс 6.0%-иар, өмнөх сараас 3.8%-иар өсч 1.738-д хүрлээ.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд экспортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6%-иар, импортын үнийн индекс 11.0%-иар буурсан нь нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтанд төмрийн хүдэр, түүхий нефтийн хилийн дундаж үнийн бууралт голлон нөлөөлсөн бол импортын үнийн бууралтанд суудлаас бусад машин, тоног төхөөрөмж, ОХУ-аас импортлож буй нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан зэрэг нь голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 5 сар			Өөрчлөлт			
	2015	2014	2013	2015/2014		2014/2013	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	3 316,3	4 059,8	4 111,3	(743,5)	-18,3%	(51,5)	-1,3%
Экспорт	1 869,3	1 927,9	1 643,3	(58,6)	-3,0%	284,7	17,3%
Импорт	1 447,0	2 131,9	2 468,1	(684,9)	-32,1%	(336,2)	-13,6%
Тэнцэл	422,3	(204,0)	(824,8)	626,3		620,8	-75,3%

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



## Бүтэц: 87% + 13%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурч нийт экспортын 87%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 85%, нийт экспортын 74%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 4.7 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 3.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

## Өсөлт: -3.0%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 3.0%-иар буурсан бөгөөд уг бууралтын 1.6%-ийг ашигт малтмалын экспортын бууралт бүрдүүлжээ. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмалын экспортын өсөлт нь уг бүлгийг 10%-иар өсөхөд нөлөөлсөн бол чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 33%, 37%, 38%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 17%-иар бууруулжээ. Бусад бараа бүтээгдэхүүний экспорт өсөхөд машин механик тоног төхөөрөмжийн дахин экспорт болон тунгаасан зэсийн экспорт голлон нөлөөлсөн.

## Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 178.5 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 237.1 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 58.6 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 273 сая ам.доллараар өссөн бол чулуун нүүрсний экспортын тоо хэмжээ буурсан, мөн чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 323 сая ам.доллараар буурсан байна.

Ямааны угаасан ноолуурын үнэ, тоо хэмжээ буурснаар уг бүлгийн экспорт 58.4 сая ам.доллараар буурсан. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс 29.3 сая ам.доллараар экспорт өссөн байна.

## Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2015 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар унц тутамд 1,190.6-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 4.7%-иар буурч, өмнөх сараас 0.5%-иар өссөн байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2015 оны 5 дугаар сарын 29-ний байдлаар 6,005.2, 60.0 ам.долларт тус тус хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэсийн үнэ 5.6%-иар буурч, төмрийн хүдрийн үнэ 1.7%-иар өсчээ. Харин өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал зэс 13.2%-иар, төмрийн хүдэр 34.6%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2015			2014			Өөрчлөлт		
	Тооцм (мянц.долл.)	Дүн	%	Тооцм (мянц.долл.)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2
<b>1. Ашигт малтмал</b>	<b>1 619</b>	<b>87%</b>		<b>1 680</b>	<b>86%</b>		<b>(31)</b>	<b>-2%</b>	<b>-1.6%</b>
Чулуун нүүрс	5 174	238	13%	7 245	355	18%	(1 171)	-33%	-7%
Зэсийн баяжмал	536	887	47%	434	718	37%	169	24%	10%
Төмрийн хүдэр/баяжмал	1 867	96	5%	1 932	154	8%	(58)	-3%	-3%
Боловсруулаагүй нефть	3 164	161	9%	2 610	259	13%	(93)	-3%	-6%
Цайрын хүдэр ба баяжмал	50	63	3%	36	36	2%	26	73%	2%
Мөнгөнөөцгүй алт	3 362	133	7%	2 171	90	5%	43	48%	3%
Жонш лайцит, нефелинг	107	25	1%	114	25	1%	(1)	-2%	0%
Мөлийн хүдэр ба баяжмал	2	15	1%	2	12	1%	3	23%	0%
<b>2. Ноос, ноолуур</b>	<b>91,1</b>	<b>5%</b>		<b>143,1</b>	<b>8%</b>		<b>(57)</b>	<b>-38%</b>	<b>-3,0%</b>
Ямааны угаасан ноолуур	1 960	80	4%	2 432	138	7%	(58,4)	-42%	-3%
Ямааны самнасан ноолуур	184	11	1%	97	10	1%	1,4	15%	1%
<b>3. Бусад</b>	<b>169</b>	<b>9%</b>		<b>130</b>	<b>7%</b>		<b>29</b>	<b>23%</b>	<b>1,5%</b>
<b>Нийт дүн</b>	<b>1 869</b>			<b>1 928</b>			<b>(58,6)</b>	<b>-3,0%</b>	

% - Бүтэйн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)  
%2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
<b>1. Ашигт малтмал</b>	<b>182</b>		<b>(213)</b>		<b>(31)</b>	
Чулуун нүүрс	(102)	-87%	(15)	-13%	(117)	-33%
Зэсийн баяжмал	169	100%	0	0%	169	24%
Төмрийн хүдэр ба баяжмал	(5)	-9%	(52)	-91%	(58)	-37%
Боловсруулаагүй нефть	56	56%	(153)	-156%	(99)	-38%
Цайрын хүдэр ба баяжмал	15	56%	12	45%	26	73%
Мөнгөнөөцгүй алт	49	114%	(6)	-14%	43	48%
Жонш лайцит, нефелинг	(1)	-289%	1	189%	(1)	-2%
Мөлийн хүдэр ба баяжмал	3	82%	1	18%	3	29%
<b>2. Ноос, ноолуур</b>	<b>(20,4)</b>		<b>(36,6)</b>		<b>(57,0)</b>	
Ямааны угаасан ноолуур	(23,1)	-50%	(23,3)	-50%	(58,4)	-42%
Ямааны самнасан ноолуур	8,7	614%	(7,3)	-514%	1,4	15%
<b>3. Бусад</b>	<b>17</b>	<b>56%</b>	<b>13</b>	<b>44%</b>	<b>29,3</b>	<b>23%</b>
<b>Нийт</b>	<b>178,5</b>		<b>(237,1)</b>		<b>(58,6)</b>	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



## Бүтэц: 30% + 36% +19%

Эхний 5 сарын байдлаар нийт импортын 30%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 36%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 19%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар буурсан бол хэрэглээний бүтээгдэхүүний хувийн жин 4%-иар өссөн байна.

## Өсөлт: -32.1%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 17%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт нь 6%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт нь 8%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 42%-иар буюу 366 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 21%-иар буюу 119 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 39%-иар буюу 172 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 32.1%-иар буюу 685 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

## Задаргаа

**Хэрэглээний бүтээгдэхүүний импорт** өнгөрсөн оны мөн үеэс 21%-иар буюу 119 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 16%-иар буюу 45 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 28%-иар буюу 74 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, какао, шоколад болон согтууруулах болон согтууруулах биш ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 23%-д хүрсэн /Дүрслэл 7/. 2014 оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6 сараас эхлэн буурчээ.

**Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт** буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 48%-иар буюу 251 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 30%-иар буюу 80 сая ам.доллараар буурсан байна.

**Аж үйлдвэрлэлийн орцын импорт** 14%-иар буюу 34 сая ам.доллараар буурсан. Уг бууралтыг бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай орцын бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

**Нефтийн бүтээгдэхүүний импорт** 39%-иар буюу 172 сая ам.доллараар буурсан. Нефтийн импорт тоо хэмжээний хувьд өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан боловч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр ийнхүү буурсан байна.

Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ 2013 оны төгсгөлөөс эхлэн тогтмол буурсан ба 2015 оны 2 сард 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн. Харин 2015 оны 3 сараас эхлэн эргэн өсч, 5 сарын байдлаар тонн тутамд 634.2 ам.долларт хүрчээ.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)


Төрөл	2015		2014		Өөрчлөлт		
	Дмн	%	Дмн	%	Дмн	Өсөлт	%
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>438</b>	<b>30%</b>	<b>557</b>	<b>26%</b>	<b>(119)</b>	<b>-21%</b>	<b>-6%</b>
Түргэн эдэлгээтэй	247	17%	292	14%	(45)	-16%	-2%
Хүнс	168	12%	202	9%	(34)	-17%	-2%
Эм, тариа	30	2%	32	2%	(2)	-7%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	49	3%	58	3%	(9)	-15%	-2%
Удаан эдэлгээтэй	191	13%	265	12%	(74)	-28%	-3%
Гулалт, хувцас, цулж	18	1%	25	1%	(7)	-28%	0%
Гэр ахуйн цах хэрэгсэл ба тавилга	42	3%	50	2%	(8)	-16%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	105	7%	156	7%	(52)	-33%	-2%
Бусад удаан эдэлгээтэй бараа	27	2%	34	2%	(7)	-21%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>514</b>	<b>36%</b>	<b>600</b>	<b>41%</b>	<b>(366)</b>	<b>-42%</b>	<b>-17%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	270	19%	521	24%	(251)	-48%	-12%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	45	3%	161	8%	(116)	-72%	-5%
Машин механик тоног төхөөрөмж, эд анги	225	16%	360	17%	(135)	-38%	-6%
Барилгын материал	183	13%	262	12%	(80)	-30%	-4%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	62	4%	97	5%	(35)	-36%	-2%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>209</b>	<b>14%</b>	<b>244</b>	<b>11%</b>	<b>(34)</b>	<b>-14%</b>	<b>-2%</b>
Хүнсний орц	13	1%	17	1%	(4)	-23%	0%
Хилийн бүтээгдэхүүн	41	3%	37	2%	4	11%	0%
Дэвүү, утас, арьс, савхин эргэлт	7	0%	6	0%	1	21%	0%
Цэвэлтэн эрчим хүч	53	4%	47	2%	6	13%	0%
Металлын хүүдэр, баялаг болон хаягдал	1	0%	0	0%	1	289%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай	94	7%	137	6%	(42)	-31%	-2%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>269</b>	<b>19%</b>	<b>441</b>	<b>21%</b>	<b>(172)</b>	<b>-39%</b>	<b>-8%</b>
Дивааль түнш	140	10%	237	11%	(97)	-41%	-5%
АИ-92, АИ-95	93	6%	134	6%	(41)	-31%	-2%
А-80 болон бусад	37	3%	70	3%	(33)	-47%	-2%
<b>Бусад</b>	<b>15</b>	<b>1%</b>	<b>10</b>	<b>0%</b>	<b>6</b>		<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>1 447</b>		<b>2 132</b>		<b>(685)</b>	<b>-32.1%</b>	

% - Бүтэйн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)  
%2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

